



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/279

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Эзэмшил газраа гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй иргэн М.Гантулгын 18-р байрны ард байрлах 040700247-1 нэгж талбарын дугаар бүхий Тоглоомын талбайтай газар доорх автогражын зориулалттай 1800 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

2.Хүчингүй болсон газрын мэдээллийг улсын бүртгэлд тусгуулж, газар эзэмшигчид мэдэгдэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

3.Газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг зэрэг бусад бичиг баримтыг хураалгахыг иргэн М.Гантулгад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 658 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010709